

**ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2022 оны 12 дугаар сарын 20

Рашаант

Нэг.Нийтлэг үндэслэл

Монгол улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйл, 7.2 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр тогтоол “Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1.3 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/142 дугаарт захирамж болон бусад холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтнаас, дотоод хяналт шалгалтын талаар гаргасан шийдвэрийг удирдлага болгосон

Хоёр.Зорилго

Байгууллагын үйл ажиллагаа, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, дээд газрын тогтоол шийдвэр, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны шийдвэрт нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, аливаа эрсдэлээс хамгаалах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, арга зүйн зөвлөгөө өгөх, ёс зүйн зөрчил, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд оршино.

№	Хийгдэх ажил	Хэрэгжилт
1	2	5
Нэг. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавих		
1	Засгийн газрын тогтоол	Байгууллагын хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд журмын дагуу хувиарт хугацаанд нь хяналт хийж гүйцэтгэлийн мэдээллийн цахим систем болон ХХААХҮЯ-д хүргүүлсэн. Тайлант онд 20 хууль тогтоомж тогтоол шийдвэрийн 67 заалт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 99.36 хувьтай дүгнэгдсэн.
2	Засгийн газрын мөрийн хөтөлбөр	Хяналтад байгаа 14 заалт арга хэмжээний хэрэгжилт 98.57 хувьтай дүгнэгдсэн.
3	ХХААХҮЯ-ын сайдтай Аймгийн Засаг даргын байгуулсан гэрээ	Хяналтад байгаа 44 заалт арга хэмжээний хэрэгжилт 97.72 хувьтай дүгнэгдсэн.
4	Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөө	Хяналтад байгаа 13 заалт арга хэмжээний хэрэгжилт 100 хувьтай дүгнэгдсэн.
5	ИТХ-ын тогтоол, шийдвэр	Хяналтад байгаа 2 заалт арга хэмжээний хэрэгжилт 100 хувьтай дүгнэгдсэн.
6	Аймгийн Засаг даргын захирамж	Хяналтад байгаа 52 заалт арга хэмжээний хэрэгжилт 99.41 хувьтай дүгнэгдсэн.
7	Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Хяналтад байгаа 16 заалт арга хэмжээний хэрэгжилт 98.75 хувьтай дүгнэгдсэн.

1	2	3
11	Байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө	Байгууллагын стратеги төлөвлөгөө батлаагүй гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан.
12	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө	Тайлант онд төлөвлөсөн 34 заалт арга хэмжээний хэрэгжилт 98.2 хувьтай дүгнэгдсэн.
13	Албаны хагас жилийн бичмэл тайлан	Албадын хагас жилийн бичмэл тайлантай танилцаж, дүгнэлт хийсэн
14	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал	Хяналтад байгаа 46 заалт арга хэмжээний хэрэгжилт 100 хувьтай дүгнэгдсэн.
15	ХХААХҮЯам болон аудитаас өгсөн зөвлөмж	Яамны ХШҮ-ны газраас ирүүлсэн зөвлөмжийг хангах зорилгоор гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөг боловсруулсан хэрэгжилтийг бүрэн хангасан.
16	Үндэсний хөтөлбөрүүд	Хяналтад байгаа 6 үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг 95 хувьтай хангасан.
17	Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт	Хяналтад байгаа 6 дэд хөтөлбөрийн хэрэгжилт 98.35 хувьтай дүгнэгдсэн.
Хоёр.Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, дотоод журмын биелэлт		
18	Ажилчдын ажлын байрны хөдөлмөрлөх нөхцөл, эрүүл ахуйн байдалд дүн шинжилгээ хийх,	Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн төрийн байгууллагуудын төсөв танагдсан хэдий ч 2022 онд нийт 21 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулахад зарцуулсан байна. Үүнд: - Албан хаагчдыг томилолтоор ажиллахад аюулгүй байдлыг хангах зорилгоор автомашиныг засварлах, - Ус цэвэршүүлэгч төхөөрөмж - 1 - Хэвлэгч төхөөрөмж -2 - 15 үзүүлэлт бүхий иж бүрэн компьютер - 5
19	Нэгж тус бүрээр ажлын цагийн нэгдсэн хуваарийн дагуу ажил эхлэх, дуусах, үдийн цайны завсарлага цагийн хуваариар явагдаж байгаад хяналт хийх	Ажлын цаг ашиглалтыг сайжруулах, цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэхэд анхаарах, сэрэмжлүүлэг өгч ажилласан. ERP системийн цаг бүртгэлийн цэсийг байгууллагын координатын өгөгдөл бүхий QR кодыг ашиглан өдөрт 2 удаа бүртгүүлэн ажиллаж хэвшүүлсэн.
20	Компьютер, техник, тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл, ашиглалт, эрсдэлийг тооцоолох	Техник хэрэгслийн ашиглалтыг сайжруулах, эвдрэл гэмтлийг сэргээн засварлаж ажиллахад байгууллагын IT-д зөвлөмж өгч ажилласан.
21	Мэргэжилтнүүдийн ажлын ачаалалд хяналт үнэлгээ өгөх, ажлын тэнцвэрт байдлыг хангах чиглэлээр асуудал дэвшүүлэх	Ажлын ачааллыг тэнцвэржүүлж, жигд ажиллах зарчмыг баримтлсан.
Гурав. Албан хаагчдын ёс зүйн дүрмийн хэрэгжилт		
22	Төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахин хамгаалсан байдал	Байгууллагын ёс зүйн төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг 100 хангасан.

1	2	3
23	Төрийн албан хаагчийн сахилга хариуцлагын асуудал	Байгууллагын сахилга хариуцлагын төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг 100 хангасан.
24	Ажлын байрны дарамтгүй орчин бүрдүүлсэн эсэх түүнээс урьдчилан сэргийлэх	Ажлын байрны дарамтаас ангид хамт олон болох үүднээс байгууллагын дотоод журамд хамааралтай заалтуудыг тусган батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
25	Иргэдээс ирүүлсэн, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, хяналт тавих	Хүнс, хөдөө аж ахуйн газарт иргэд, ААН, байгууллагаас хандаж ирүүлсэн нийт 54 санал, хүсэлтийг журмын дагуу хүлээн авч, бүртгэн, 100% шийдвэрлэж, тухай бүр хариуг мэдэгдэж ажилласан. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг холбогдох журмын дагуу улирал бүрийн сүүлийн сарын 25-ны өдрийн дотор АЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлж хэвшсэн.
Дөрөв. Шилэн данс, Өмчийн бүртгэлийн тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, тавих хяналт шалгалт		
26	Шилэн дансны бүртгэл хөтлөлтийг хянах	Бүтэн жилийн байдлаар хугацаатай 158 мэдээлэл оруулахаас хугацаандаа орсон 137, хугацаа болоогүй 14, хугацаа хоцорсон 8 мэдээлэл байна.
27	Эд хөрөнгийн тооллогын комиссын үйл ажиллагаанд хяналт тавих	Байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих, бүрэн бүтэн байдлыг хангуулсан.
28	Актлах эд хөрөнгийн жагсаалтад хяналт тавих	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3 дахь заалтууд байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хурын тэмдэглэлийг үндэслэн байгууллагын бараа материалын дансанд бүртгэлтэй хавсралтад заасан 3.8 сая төгрөгийн үнэ бүхий 23 нэр төрлийн бараа материалуудыг акталж данс бүртгэлээс хассан. Мөн дээрх заалтыг үндэслэн мэргэжлийн хяналтын газрын Ургамал хорио цээрийн хяналтын улсын байцаагчийн 2022 оны 11 дүгээр сарын 21-ны өдрийн 05-02-008/131 дэх дүгнэлтийг тус тус үндэслэн байгууллагын бараа материалын дансанд бүртгэлтэй 9.8 сая төгрөгийн үнэ бүхий төл сонгино үрийн төмсийг акталж бүртгэлээс хассан.

ХЯНАСАН.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН

ГҮЙЦЭТГЭГЧ

У.БАЛЖИННЯМ

НЭГТГЭСЭН:

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.ЦЭРЭНХАНД

